



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 20-р хороо, Гачуурт тосгон
Утас: 976-11-710154; 976-11-710041; 976-11-315513 Факс: 976-11-710154; 976-11-325861
И-Мейл: info@hotel-mongolia.com Вебсайт: www.hotel-mongolia.com

ТАНИЛЦУУЛГА

“Монгол Шилтгээн” ХХК нь анх “Гачуурт тур” ХХК нэртэйгээр 2001.08.22нд Гачуурт тосгон дах спорт амралтын цогцолборын үндэс суурин дээр гадаад дотоод худалдаа, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр байгуулагдсан.

2004 оны 8-р сарын 11-нд “Гачуурт тур” ХХК гэсэн оноосон нэрээ “Монгол Шилтгээн” болгон өөрчилсөн болно.

“Монгол Шилтгээн” ХХК нь Монгол Улсын иргэн С.Отгонбаатар, ХБНГУ-ын иргэн Клаус Бадер нарын хооронд байгуулсан гэрээний дагуу байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.

Монгол Шилтгээн ” ХХК нь өөрийн “ Монгол Шилтгээн ” зочид буудал, амралтын цогцолбортой ба уг цогцолбор нь 2003 оны 7 дугаар сараас үйл ажиллагаагаа эхэлж дотоод, гадаадын зочид жуулчдыг хүлээн авч байна.


Цогцолбор нь Монголын эртний нийслэл Хар-Хорин хотын загвар, үндэсний уран барилгын өвөрмөц хэв маягаар баригдсан бөгөөд Улаанбаатар хотын төвөөс зүүн тийш 20 км зайтай Гачуурт тосгоны нутаг дэвсгэрт Туул голын эрэг Хар усан тохойн орчим байрладаг.

“Монгол шилтгээн” цогцолбор нь улирлын чанартайгаар 5-р сараас 10-р сар хүртэл үйл ажиллагаа явуулах бөгөөд зочид буудлын орны тоо 100, нэг ээлжиндээ 300 орчим хүн хүлээн авах хүчин чадал бүхий дээд зэрэглэлийн ресторан, 50 хүний суудалтай баар, амьд хөгжмийн тоглолт, массаж, бэлэг дурсгал, эртний эдлэлийн дэлгүүрүүд, бизнес төв, хурлын танхим “Чингисийн өргөө”, Монголын Эзэнт Гүрний цогцолбор, түүдэг галын павильон, бэсрэг наадмын талбайтай..

Зочид буудал нь орчин үеийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон 10 хагас люкс, 50 энгийн өрөөтэй. Үүнээс 16 өрөө нь Монголчуудын нүүдэлчин амьдралын хэв маягийг хадгалсан гэр буудалд, 24 өрөө нь сүм хэлбэрийн буудалд, 10 өрөө нь хэрмэнд байрладаг бөгөөд өрөө бүр Алтан ургийн хаад, Чингисийн өрлөгүүд, Монголын хатад, Монгол аймгуудын нэрээр нэрлэгдсэн. Буудлын өрөөний үнэ нь жуулчны ба жуулчны бус улирлаас шалтгаалахаас гадна люкс,хагас люкс, энгийн зэрэг өрөөний төрлөөс хамаарч тогтоогддог.

Үүнээс гадна “Монгол Шилтгээн” ХХК нь Монголын ёс заншлыг гадаад дотоодын зочин гийчинд таниулах зорилгоор бэсрэг наадам, түүдэг галын наадам, XIII зууны үеийн Монголын Эзэнт Гүрнийг дүрсэлсэн байгууламжид долоо хоногт 2-3 удаа “Монголын нэг өдөр” тусгай хөтөлбөр зохион байгуулж байна. Энэхүү хөтөлбөрүүд нь Монголын ард түмний арвин баялаг түүх, соёл, зан заншилтай танилцаж, ардын язгуур урлаг, шашны зан үйл, уламжлалт тоглоом, баяр наадмыг үзүүлэхээс гадна хүссэн зочинд өөрийн биеэр мэдэрч оролцох боломж олгодог онцлогтой юм.

Цаашилбал “Монгол Шилтгээн” ХХК нь дотоод гадаадын жуулчдад зориулсан олон шинэ үйлчилгээнүүд нэвтрүүлэх гэж байгаа ба Монголд ирсэн зочид гийчдэд мартагдашгүй таатай сэтгэгдэл үлдээж Монголд ирэх жуулчдын тоог нэмэхийг гол зорилгоо болгон ажиллаж байна .



Компаний үндсэн үйл ажиллагаа : Ресторан , зочид буудлын үйлчилгээ, гадаад дотоод худалдаа, тур оператор зэрэг болно .

Компаний хаяг : Баянзүрх дүүрэг , 20-р хороо ,Гачуурт тосгон, Монгол Шилтгээн

Компаний эрхэм зорилго : Компаний эрхэм зорилго нь ресторан зочид буудлын үйлчилгээний олон улсын стандартыг Монголд нэвтрүүлэх, Монгол Улсыг олон улсад сурталчлах нэрийн хуудас болох

“Монгол Шилтгээн” ХК-ийн удирдлага зохион байгуулалтын бүтэц

Хавсралт №2

Компаний эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал байна . Хувь нийлүүлэгчдийн хурлаар компаний санхүүгийн болон үндсэн үйл ажиллагаа, удирдлага , зохион байгуулалтын асуудал зэргийг шийдвэрлэнэ . Хувь нийлүүлэгчдийн хурлын чөлөөт цагт компаний эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байх бөгөөд ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна . Төлөөлөн удирдах зөвлөл болон Хянан шалгах зөвлөлийг Монгол Улсын “ Компаний тухай” хуульд зааснаар сонгоно .

Нэг хувьцаа саналын нэг эрхтэй байх бөгөөд компаний саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно .

Хянан шалгах зөвлөл нь Монгол Улсын “Компаний тухай” хууль болон компаний дүрэмд заасан дараах үйл ажиллагааг явуулна.

- компаний үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох
- компаниас нэмж үнэт цаас гаргах, тэдгээрийг гаргах төсөл, эдийн засгийн үр ашгийн тооцоо зэргийг гаргах
- компаний эд хөрөнгө , үнэт цаасыг борлуулахад зах зээлийн үнийг тогтоох
- компаниас явуулж байгаа аливаа үйлчилгээний үнэ хөлсийг тогтоох
- компаний жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах
- компаний салбар болон төлөөлөгчийн газар байгуулах

Компаний ТУЗ-ийн гишүүнийг хувь нийлүүлэгчдийн хурлаар 3 жилийн хугацаатай сонгох бөгөөд ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа хуралдуулна .

Гүйцэтгэх захирал ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компаний өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна .


Гүйцэтгэх захирал нь дараах асуудлыг өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэнэ .

- Компаний хэтийн төлөв, бодлого , үйл ажиллагааны чиглэлийг боловсруулан гаргах
- Компаний дотоод журмыг батлан гаргах
- Компанийг төлөөлж бусад гадаадын болон дотоодын байгууллага , компанитай хэлэлцээр байгуулах
- Компаний нэрийн өмнөөс аливаа асуудлаар тушаал, шийдвэр гаргах
- Компаний боловсон хүчнийг сонгон шалгаруулж ажилд томилох, компаний ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулж боловсон хүчний бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх зэрэг болно .



Хавсралт №2

"Монгол Шилтгээн" ХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц



БҮРТГЭВ. 02
Бүртгэл хяналтын
Алба 46

ҮЦХ
... он ... сар ... өдөр
БҮРТГЭВ
№02



“Монгол Шилтгээн” ХК –ийн салбар төлөөлөгчийн газар

“Монгол Шилтгээн” ХК нь одоогийн байдлаар охин компани , салбар компани төлөөлөгчийн газар үгүй болно .

“Монгол Шилтгээн” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн хэмжээ

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2 320 000 ам доллар (Хоёр сая гурван зуун хорин мянган) ам доллар байна .

“Монгол Шилтгээн” ХК-ийн эрх бүхий албан тушаалтны хариуцлага хүлээсэн байдал

“Монгол Шилтгээн” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнууд нь сүүлчийн 3 жилд төрийн захиргааны байгууллагын болон шүүхийн шийдвэрээр хариуцлага хүлээж байгаагүй болно .

“Монгол Шилтгээн” ХК урьд өмнө үнэт цаас гаргаж байсан байдал

“Монгол Шилтгээн” ХК нь урьд өмнө нь энгийн хувьцаа, түүнд хөрвөх болон хамаарах үнэт цаас гаргаж байгаагүй болно .

“Монгол Шилтгээн” ХК-ийн нийт өр авлагын үзүүлэлтүүд

(Хавсралтаар 3.1.3.2 –аар дэлгэрэнгүй 2004 оны 4-р улирлын санхүүгийн тайлангаар)

Үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулга

Үнэт цаасны бүрдүүлбэр дараах байдалтай байна :

Үнэт цаасны нэр , төрөл	:	энгийн хувьцаа
Үнэт цаасны нэр	:	“Монгол Шилтгээн” ХК
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ	:	290 төгрөг
Компаний зарласан хувьцаа	:	10 000 000 (арван сая) ширхэг

Компаний нийт зарласан хувьцаанаас олон нийтэд арилжаалах шийдвэрийг компаний дүрэмд зааснаар ТУЗ гаргана .

Үнэт цаасыг санал болгох хүрээ

“Монгол Шилтгээн” ХК-ийн нийт зарласан 10 000 000 (арван сая) ширхэг хувьцааны 1 000 000 (нэг сая)-г нийтэд нээлттэйгээр худалдана .

Үнэт цаас гаргаж хуримтлуулах хөрөнгийн зориулалт

Компаний нийт гаргасан хувьцааны тоо 10 000 000 (арван сая) ширхэг , нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 290 төгрөг.

Тус компаний үндсэн үйл ажиллагаа нь ресторан зочид буудал ,аялал жуулчлал ба Монгол Улсын нэрийн хуудас болох зорилготой тул өөрийн компаний үйл ажиллагааг өргөтгөх мөн дотоод гадаадын зочид гийчдийн тоог нэмэх зорилготойгоор шинэ үйлчилгээ нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байгаа ба эдгээр үйлчилгээг нэвтрүүлэхэд нэмэлт хөрөнгө оруулалт зайлшгүй шаардлагатай байгаа тул үнэт цаас гаргаж хуримтлуулах хөрөнгөө нэмэлт хөрөнгө оруулалт хийхэд зориулах болно . (Хавсралт № 4)

Хөрөнгө оруулагчдад учирч болох эрсдэл

Аялал жуулчлалын зах зээл хөгжиж байгаа өнөө үед Зах зээлийг зохицуулах хууль эрх зүйн актууд, давагдашгүй хүчин зүйлүүдээс гадна өвчин гарах болон бусад байдлаар Монгол орныг сонирхох сонирхол буурах зэрэг гадаад хүчин зүйл болон компаний дотоод үйл ажиллагаа , компаний үндсэн болон санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанаас шалтгаалан хөрөнгө оруулагчид тодорхой хэмжээний эрсдэл хүлээж болно .

